



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр

Дугаар ХЭТ/1845

Улаанбаатар-12  
Утас 260817  
Факс: 976-11-310011

И.Фармбэй -ү

Сэтгэр агуулам, үйл  
Ажиллагааны ажлаар  
Хэрэгжилтийг хангах  
ажлаар

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Ц.МӨНХБАТ ТАНАА

Ц.Мөнхбат 20/04

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу яам, аймаг, нийслэлийн 2021 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд хуралдааны 28 дугаар тэмдэглэл болон яам, аймаг, нийслэлийн үйл ажиллагааг дүгнэсэн үзүүлэлт тус бүрээр гарсан дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна.

Тэмдэглэл, зөвлөмж, дүгнэлтэд үндэслэн төлөвлөгөө гарган ажиллаж, удаашралтай зорилт, арга хэмжээг эрчимжүүлэн зорилтот түвшинд хүргэх, хэрэгжилт хангалтгүй байгаа ажлуудыг анхаарч, тодорхой үр дүнд хүргэж ажиллана уу.

Хавсралт 16. хуудастай.

Х.Сүхбаатар  
и.Фармбэй



Бодлогын баримт бичгийн  
нийтлэг журам, Дэд дарга  
сайн дураар

И.Фармбэй 20/04

У.БЯМБАСҮРЭН



**ДУНДГОВЬ АЙМГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН  
ХЭРЭГЖИЛТ БОЛОН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН  
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ,  
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

16

УЛААНБААТАР  
2022 ОН

## **НЭГ. ЗОРИЛГО**

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлтүүдэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

## **ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу аймгийн 2021 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгүүдийг хамруулсан. Үүнд;

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- Аймаг, нийслэлийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөөний биелэлт;
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ.

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох:

- Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт;
- Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт.

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох:

- Байгууллагын ил тод байдлын үнэлгээ;
- Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ;
- Шударга байдлын түвшний үнэлгээ зэрэг 11 үзүүлэлтүүдийг хамруулсан болно.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2, 6.3 –т заасан арга зүйгээр дээрх 11 үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тухайн ирүүлсэн тайлангаас гадна холбогдох нэгж, байгууллагаас нэмэлт тодруулага авах, хамааралтай баримт бичиг болон статистик мэдээлэл, бусад байгууллагаас хийгддэг судалгааны дүнтэй харьцуулалт хийсэн болно. Мөн 2020 онд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзлээ.

Журамд заасны дагуу нэгдсэн үнэлгээг тооцохдоо бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох 4 үзүүлэлт нийт үнэлгээний 60 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох 2 үзүүлэлт 20 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох 4 үзүүлэлтийг 20 хувиар тус тус тооцсон. Эдгээр үзүүлэлтээс шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Сангийн яам, шударга байдлын үнэлгээг Авилгатай тэмцэх газраас зарласан үнэлгээг шууд авч ашигласан болно.

## **ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

**3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт:**

Тус аймаг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажилд ач холбогдолтой хандаж, өгсөн дүгнэлт, зөвлөмж, сургалтаар олгогдсон мэдлэг, арга зүйг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажилласан байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны жилийн эцсийн тайланг Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулсан тэмдэглэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн





1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	18.1.3.. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Аймгийн хэмжээнд 2021 оны 11 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн зөрчил 36, энэ нь өмнөх онтой харьцуулахад 6 нэгжээр, гэмт хэрэг 13, өмнөх онтой харьцуулахад 7 нэгжээр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Гэр бүлийн хүчирхийллийн аюулын зэргийн үнэлгээ нь дунд, өндөр эрсдэлтэй хохирогчийг төрөл, садан ойр дотных нь хамгаалалтад өгч ажиллаж байна. Мөн Хамгаалах байрыг шийдвэрлэх асуудлаар Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас "Түр хамгаалах байр" бий болгох төсвийн тооцоолол, саналыг дараах албан бичиг тоотоор 2021.04.21 №53, 2021.04.22 №53, 2021.10.12 №132, 2021.10.12 №133 аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлсэн, төсөв санхүүгээс шалтгаалж шийдвэрлэх хариу ирээгүй байна.	30%	30%	
Ерөнхийлөгчийн зарлиг						
2		1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох	Сайнцагаан сумын 7-р багийн нутагт "Цэцэрлэгт хүрээлэн" байгуулах зориулалтаар 7300м2 газрыг хамгаалалтанд аваад байна. 2021 онд шинээр Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Дэрэн, Гурвансайхан, Говь-Угтаал сумдад тус бүр 1 га нийт 5 га талбайд ойн зурвас байгуулсан.	100%	30%	Бодит үр дүнг нэмэгдүүлэх
3	2 Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах	Хавсралт : 1 зураг Орхон голоос эх авч Онги голын урсацыг нэмэгдүүлэн Улаан нуурыг тэтгэж, улмаар говийн бүсийн сум суурингийн хүн ам, бэлчээр, хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн ус хангамжийн найдвартай эх үүсвэр бий болгох, эрчим хүч үйлдвэрлэх зорилготой "Орхон-Онги" эко төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байна. Тус төслийн ТЭЗҮ-ийг "Хайдродизайн прожект" ХХК, "Престиж инженеринг" ХХК, "Монхидро констракшн" ХХК, "Жемер" ХХК-иуд хамтран гүйцэтгэж байна. Баянжаргалан, Өлзийт сумдад хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсвийг "Гидро сооружение" ХХК-аар гүйцэтгүүлсэн. "Цэнхэр алт-Ногоон хэрэм" монголын үндэсний усны ассоциаци Сайхан-Овоо сумын Онгийн хийдээс доош, хавцлаас уруудан гарах хэсэгт ус хуримтлуулах зорилгоор 13м-ийн өндөртэй боомтоос хэрэглээний усыг Цамхагт ус гаргуураар гаргахаар, үерийн үеийн усыг боомтын хажуу талын салаа голруу сувгаар урсахаар төлөвлөсөн. Онги гол дагуу 5,5 мян.га-д мод тарихаар төлөвлөн ажиллаж байна.	70%	30%	
4		1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт	Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд модны нүх ухагч бага оврын тракторыг хот	70%	30%	

		<p>тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх</p>	<p>тохижуулах газарт авч өгсөн. Мөн 15 суманд мод тарихад дэмжлэг үзүүлж сум тус бүрд 2 сая нийт 30 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯамны ойн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн.</p>		
5		<p>2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.</p>	<p>"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний Дундговь аймаг дахь нээлтийг 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр албан ёсоор эхлүүлж, төрийн байгууллагуудын удирдлагуудад мэдээлэл хийлээ. Намрын "Бүх нийтээр мод тарих өдөр"-өөр "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний нээлтийн мод тарих, тарьц суулгацын үзэсгэлэн худалдаа, нөхөн тарилт хийх тарьц суулгац тараах ажил зохион байгуулав. Мөн энэ өдөр Шаргын хөшөөний урд хэсэгт зам дагуу мод тарив. Тус хөдөлгөөний нээлтийн мод тарих үйл ажиллагаанд 15 байгууллагын 200 иргэн оролцлоо. Гурвансайхан суманд ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг "Эрдэнэс силвер ресурс" ХХК 2030 он хүртэл 3.0 сая мод тарих амлалт өгч, гэрээ байгуулсан.</p>	100%	30% Бодит үр дүнг нэмэгдүүлэх
		<b>ЗГ-ын тогтоол</b>			
3	<p>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай 2020-04-22 Дугаар 2020_144</p>	<p>3. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулах барилга байгууламжид дулааны эрчим хүчний тоолуур суурилуулсан байх шаардлагыг холбогдох дүрэм журамд тусгайлан зааж мөрдүүлэх, цаашид цахилгаан, дулааны эрчим хүчний бодит өртөг, зардал суурилсан үнэ тарифыг тогтоож мөрдүүлэх, дулааны эрчим хүчний хөндлөн татаасыг зогсоох, нэгжийг тэгшитгэх, дулааны эрчим хүчний хэрэглээг зөвхөн тоолуураар тооцдог байх асуудлыг судлан холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт болон Эрчим хүчний зохицуулах хороо (А.Тлейхан)-нд тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Аймгийн хэмжээнд дулааны тоолуур суурилуулах шаардлагатай 176 барилга байгууламжийн судалгааг Эрчим хүчний яам болон Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлсэн. Барилга бүрээр тоолуур суурилуулах зардлын тооцоог гаргах шийдвэр өгч, холбогдох мэргэжлийн байгууллага болох Ултра соник ХХК-аар тооцоог гаргуулсан хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй.</p> <p>Хавсралт : 3 зураг</p>	30%	30%

**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмж:**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж удирдлагуудыг тасралтгүй, үнэн зөв мэдээллээр хангаж, хариуцлага, сахилга батыг нэмэгдүүлэн ажиллах.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн аливаа төслийг боловсруулахдаа урьдчилан судалсан, холбогдох тооцоо судалгаа, үр нөлөө, ач холбогдлыг тооцсон, санхүү хөрөнгийн эх үүсвэр нь шийдвэрлэгдсэн, хэрэгжихүйц тохиолдолд хэлэлцүүлэх. Нэг утга агуулга бүхий асуудлаар давхардуулан шийдвэр, заалт гаргахгүй байх. Тухайн шийдвэр, заалтыг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтны нэрийг тодорхой зааж албажуулдаг байх.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахдаа арга хэмжээ болон хөрөнгийн эх үүсвэр, шууд хариуцан гүйцэтгэх байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон төлөвлөгөө, удирдамж баталж, биелэлтийг хангуулах талаар эрчимтэй ажиллах.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, удирдамжийн дагуу хэрэгжилт хангалтгүй байгаа шийдвэр, заалтын мэдээллийг хэлэлцэн агуулга, чиглэлээр нь багцлан бүрэн эрхийнхээ хүрээнд харъяалах байгууллага дээр нь ажиллаж үр дүнг үнэлэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар холбогдох арга хэмжээг авч байх.

Өмнө нь гарсан шийдвэр, заалтыг нэг бүрчлэн шүүн үзэж хэрэгжиж дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон заалтуудыг хяналтаас хасах, хэрэгжилт тогтмолжсон норматив шинжтэй шийдвэрийн заалтууд болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан хөтөлбөр, журмуудыг дотоод хяналтандаа авч Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сангаас тэмдэглэл хийн хасуулах.

Тодорхой шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон шийдвэр, заалтын тайлбарыг цаашид боловсронгуй болгох, хуульд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох зэрэг саналын хамт боловсруулж Засгийн газарт ирүүлж шийдвэрлүүлж байх.

Дүгнэлт, зөвлөмжтэй танилцан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг дараагийн тайлангийн танилцуулгад тусган ирүүлж байх.

**3.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт:**

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 203 дугаар тогтоолд аймаг, нийслэлийн Тамгын газар хэрэгжүүлэхээр заасан арга хэмжээнд үндэслэсэн болно.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг **71.1 хувьтай** гэж үнэлэв.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хэрэгжилт нь удааширч байгаа зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж 2021 оны зорилтот түвшинд хүргэх, 2020-2021 онд хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн боловч шаардагдах хөрөнгө нь 2022 оны орон нутгийн болон улсын төсөвт тусгагдаагүй арга хэмжээнүүдийн судалгааг гаргаж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх талаарх санал боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагад танилцуулан шийдвэрлүүлэхийг зөвлөж байна.

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНЭЭС**

3.3.9.2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ.

3.7.9.8. Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна.

3.7.12.4. Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

5.1.4.1. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.

5.1.11.2. Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулна.



6.2.5.1. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.

6.2.12.1. Аймгийн төвөөс алслагдсан сумдад ажиллаж, амьдарч байгаа эрүүл мэнд, боловсрол, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагчдын ажиллаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх хүрээнд албаны орон сууцаар хангах ажлыг зохион байгуулна.

6.2.13.1. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

**3.3. Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт:**


Дундговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2022 оны 1 дүгээр сарын 31-ны өдрийн 1/114 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт албан бичгийн бүрдлийг ханган ирүүлсэн байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 16 дугаар тоот тогтоолоор тодорхой үр дүнд хүрсэн гэж ирүүлжээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлгээг хянан үзээд **77.7** хувиар үнэлсэн болно.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувь, үнэлгээ:

### Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт



Дундговь аймгийн хэмжээнд хэрэгжсэн дэд хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж мэдээллийн цахим санд тайлагнан баталгаажуулаагүй байна.

Тайлагнасан, үнэлгээ хийгдсэн үзүүлэлтийн хэрэгжилтийн байдал:

Ангилал	Үнэлгээ	ЗДТГ-ын үнэлгээ хийсэн арга хэмжээний тоо	ЗГХЭГ-ын үнэлгээ хийсэн арга хэмжээний тоо
Үр дүнгүй	0%	20	21
Эрчимжүүлэх шаардлагатай	30%	1	12
	50%	4	12
Тодорхой үр дүнд хүрсэн	70%	3	10
	90%	4	11
Үр дүнтэй	100%	145	111
<b>Нийт дүн</b>		<b>177</b>	<b>177</b>

### Дүгнэлт

АЗҮАХ-ийн хэрэгжилтийн тайлангийн танилцуулгын хавсралтад аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй бодлого бүрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн томоохон ажлын талаар оруулсан нь ойлгомжтой мэдээлэл авахад хялбар байлаа. Мөн мэдээллийн цахим санд



арга хэмжээний талаарх бодит мэдээллийн файлаар нотлох баримт хавсарган ирүүлсэн нь бусад аймгаас давуу байсан. Өмнөх оны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд ЗГХЭГ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжилт сайн хангагдсан байна.

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс дараахь зорилт, арга хэмжээг эрчимжүүлэн тодорхой үр дүнд хүргэх шаардлагатай байна. Үүнд:

-2.1.3.1. Нэгдсэн эмнэлгийг компьютер томографи, сумдыг мобайль технологээр хангана.

-2.2.1.1.2. Монгол улсын гавьяат дасгалжуулагч А.Доржсүрэнгийн нэрэмжит есвөрийн волейболчдын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах

-2.3.1.1. Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Адаацаг, Хулд, Цагаандэлгэр суманд шинээр цэцэрлэгийн барилга барих

-2.3.1.2. 1-2 настай хүүхдийг яслийн бүлэгт, 2-3 настай хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд хамруулах

-2.3.2.1. Сайнцагаан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, сумдад шинээр сургуулийн барилга барих

-2.5.1.1. Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилга барьж, ашиглалтад оруулах

-2.5.1.2. Аймгийн Музейн барилгын зураг төсвийг хийлгэж, барилгыг барьж ашиглалтад оруулах

-2.5.3.5. Адаацаг сумын Сүм хөх бүрдэд байгалийн түүхийн музей байгуулах

-3.2.1.2. Салхитын мөнгөний ордыг ашиглахад орон нутгийн зүгээс дэмжиж, ордын тодорхой хувийг орон нутагт эзэмших асуудлыг Засгийн газар, Улсын Их Хуралд тавьж шийдвэрлүүлэнэ.

-6.1.1.7. "Аймаг, сумын төвийн бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн төслөөр хэрэгжих 5 /цэвэр усны шугам, цэвэршүүлэх, авто зам, гэрэлтүүлэг, 2-р цэцэрлэг, гадна бохир усны шугам/ төсөл арга хэмжээний ажлын хөрөнгийг шийдвэрлэх гэх мэт

#### **Зөвлөмж**

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 17.5-д "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тухайн шатны Засаг дарга батлан хэрэгжүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6.8.4-т заасан зарчмыг баримтлан төлөвлөлтийн дагуу тайлагнахад анхаарах.

Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон журмын хавсралтад заасан загвараар ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлыг төлөвлөгөөний дагуу хурдан шуурхай зохион байгуулж, 2021 оны эцсийн байдлаар тасарсан болон удааширч байгаа арга хэмжээнүүдийн шалтгааныг тодорхой болгож, хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнд хийгдсэн ажлуудыг орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч сурталчлах, мөн төрийн захиргааны байгууллага чиг үүргийн хүрээнд явуулж байгаа үйл ажиллагаа болон иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол зохион байгуулан хэвшүүлэх үр дүнтэй тайлагнаж иргэдээс гарсан саналыг жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх.

ЗДҮАХ-ийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан танилцуулга, дүгнэлт, зөвлөмжийг сайжруулах тайлагналт хэт ерөнхий байгаагаас үүдэн тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр бодлогын ямар өөрчлөлт гарсан, нийгэмд үзүүлэх эерэг нөлөө зэргийг дүгнэх боломжийг хязгаарлаж байгаад анхаарах.

#### **3.4 Аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт:**

Аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын 206 тогтоолоор баталсан журамд заасан аргачлалын дагуу үнэлэхэд **71.9 хувьтай** гарлаа.

#### **Дүгнэлт**

Дундговь аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дараах дүгнэлтийг гаргаж байна. Төлөвлөлтийг аймгийн онцлогтой уялдуулах, цаг үеийн байдлыг харгалзан ажиллаагүйгээс хэрэгжих боломжтой арга хэмжээнүүдийн биелэлт хангалтгүй болсон байна. Цар тахлын байдлаас шалтгаалж биелэгдээгүй олон арга хэмжээ байна. Тиймээс төрийн ажлыг ямар ч цаг үед тасралтгүй явуулж байх үүднээс төрийн анхан шатны нэгжийг чадавхижуулах арга хэмжээг богино хугацаанд хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

**Зөвлөмж**

1. Хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа үйл явц бус үр дүнд чиглэсэн арга хэмжээ оруулах, гарсан үр дүнг тайланд тусгах,
2. Хариуцсан нэгж, захиргаа удирдлагын газар/хэлтэс/-н дарга, албан хаагч нарын ажлын хариуцлагыг сайжруулах,
3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх жилүүдэд хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлж ажиллах.

**3.5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж:**

Аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн дагуу Дундговь аймгийн 2021 оны гүйцэтгэлийг үнэлэхэд эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт **79.8 хувиар** үнэлэгдсэн байна.

**Дүгнэлт:**

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг төлөвлөхдөө аймгийн нийгэм, эдийн засгийн суурь үзүүлэлт дээр тулгуурлан тооцоо судалгаа хийж салбарын бодлоготой уялдуулан төлөвлөх ажил учир дутагдалтай байгаагаас шалтгаалан зарим үзүүлэлтүүд зорилтот болон суурь түвшинд хүрээгүй байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх жилүүдэд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

**Зөвлөмж:**

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ суурь түвшин, хүрэх түвшинтэй харьцуулан үнэлж байх;
2. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн гүйцэтгэлийг ирүүлэхдээ мэдээллийг холбогдох эх сурвалжаас авч, үнэн бодитой тайлагнаж байх;
3. Зорилтот түвшинд хүрээгүй, суурь түвшинээс буурсан үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийж, түүний учир шалтгааныг тодорхойлж, холбогдох нэгжид дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх;
4. Цаашид төрийн захиргааны төв байгууллага болон аймгийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжтэй хамтран ажиллаж, нийгэм, эдийн засгийн төлөв байдлын талаарх албан ёсны статистик үзүүлэлтэд суурилж, салбарын бодлоготой уялдуулан эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг төлөвлөж байх.

**ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

**4.1. Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт**

БОАЖ-ын сайд	Сангийн сайд	ХЗДХ-ийн сайд	ХХАХҮ-ийн сайд	БХ-ын сайд	БХБ-ын сайд	Соёлын сайд	БШУ-ын сайд	ЗТХ-ийн сайд	УУХУ-ийн сайд	ХНХ-ын сайд	ЭХ-ний сайд	ЭМ-ийн айдс	Үнэлгээний дундаж
92.2	89.0	78.7	86.2	90.0	95.8	78.0	91.3	79.6	77.9	81.6	89.2	83.2	85.6

Засгийн газрын гишүүдтэй 2021 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг **85.6 хувь** гэж үнэлэв.

Засгийн газрын гишүүнээс аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг, яамдаас ирүүлсэн тайлан мэдээ /гэрээний биелэлтэд/ үндэслэн, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу үнэлгээ хийж нэгтгэн гаргалаа.

#### **Зөвлөмж:**

ЗГ-ын 2021 оны 374 дугаар тогтоолоор "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д өөрчлөлт орсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг журамд заасан загвар аргачлалын дагуу төлөвлөн, тайлагнаж хугацаанд нь Засгийн газрын цахим мэдээллийн /[unelgee.gov.mn/](http://unelgee.gov.mn/) санд байршуулан баталгаажуулж байх.

Цаашид хуулиар болон гэрээгээр хүлээсэн үүргийг аль аль тал биелүүлэх, гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг сайжруулахад анхаарч хяналтыг хоёр талаас тогтмол тавьж, гэрээний биелэлтийг тайлагнаж, эргэх холбоотой ажиллах нь зүйтэй байна.

#### **4.2. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт**

Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг **84.9** хувьтай гэж дүгнэв. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхой тайлбарлах, цаашид үргэлжүүлэх шаардлагатай арга хэмжээг дараа жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой тусгах, шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлох, хүрэх түвшинг тухайн жилдээ биелэгдэх боломжтойгоор тодорхойлох, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин хоёрыг уялдуулах шаардлагатай байна.

Мөн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа салбарын стратеги төлөвлөгөөний зорилт, арга хэмжээн дээр үндэслэн оновчтой, бодитой, тодорхой байх, хэмжээний хувьд хэт нүсэр байдлаар хийхгүй байхад анхаарна уу.

#### **4.3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 4 дүгээр хавсралтын дагуу Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2 зорилт, 7 үйл ажиллагааны 14 шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэв.

Зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг тооцохдоо баталгаажуулан ирүүлсэн жилийн эцсийн хэрэгжилтийн тайлангийн чанар, хугацаанд үндэслэхийн зэрэгцээ аймаг, орон нутагт шалгалт, сургалт, семинар, албан ажлаар ажиллах үед цуглуулсан мэдээлэл, бодит нөхцөл байдал, хөндлөнгийн судалгааны дүн зэргийг харгалзан үзсэн болно.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2021 оны гүйцэтгэлийг тухайн байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээлэл, дээр дурдсан бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж **78.5 хувиар** үнэлэв.

#### **Зөвлөмж:**

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг Төрийн албаны тухай хууль болон уг хуулийг дагалдаж гарсан бусад эрх зүйн актад нийцүүлэн боловсруулж, албан хаагчдын санал, бусад оролцогч талуудын зөвлөмжийг тусган хэрэгжүүлэх,

Дунд хугацаанд болон тухайн жилд авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнд гарсан өөрчлөлтийг хэмжих үүднээс шалгуур үзүүлэлтийн утга нь суурь түвшин болон өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн талаарх мэдээллийг үндсэн тайланд товч, тодорхой тусгаж, холбогдох нотлох баримт, гарсан шийдвэр, бүртгэл судалгааг хавсралтаар дэлгэрэнгүй тайлагнах,

Арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайланг нэгтгэх, хяналт-шинжилгээ хийхэд оролцож буй нэгж, албан тушаалтнууд нь удирдлага болон дээд шатны байгууллагыг бодитой мэдээллээр хангахад анхааран ажиллахыг тус тус зөвлөмж болгож байна.



## ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### 5.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралтад туссан "Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийг Үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал гэсэн үндсэн 2 ангиллын 14 шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэв.

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг тооцохдоо баталгаажуулан ирүүлсэн жилийн эцсийн хэрэгжилтийн тайланд үндэслэхийн зэрэгцээ шалгалт, сургалт, семинар, албан ажлаар орон нутагт ажиллах үед цуглуулсан мэдээлэл, бодит нөхцөл байдал, хөндлөнгийн судалгааны дүн, цахим хуудас, мэдээллийн самбарын хөтлөлт зэргийг харгалзан үзсэн болно.

Байгууллагын ил тод байдлыг хангах замаар иргэд, олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах зорилтын 2020 оны гүйцэтгэлийг тухайн байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээлэл болон дээр дурдсан бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж **70.1 хувиар** үнэлэв.

#### Зөвлөмж:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, хүнд суртлыг бууруулах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлэх,

Бүрэн хэрэгжээгүй үзүүлэлт бүрийн хэрэгжилтийг сайжруулах, мэдээ мэдээллийн чанар, хүртээмжийг чанаржуулах талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнд гарсан өөрчлөлтийг хэмжих үүднээс шалгуур үзүүлэлтийн утга нь суурь түвшин болон өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн талаарх мэдээллийг үндсэн тайланд товч, тодорхой тусгаж, холбогдох нотлох баримт, гарсан шийдвэр, бүртгэл судалгааг хавсралтаар дэлгэрэнгүй тайлагнах,

Цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж буй мэдээллийн "холбогдолтой", "цаг үеийн", "найдвартай байдал"-д илүү ач холбогдол өгч, иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүртээмжтэй, хэрэглэхэд хялбар байх зарчмыг баримтлан ажиллахыг тус тус зөвлөмж болгож байна.

### 5.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Нийт 54 ТЕЗ нарын мэдээллээс харахад, нэг төсвийн ерөнхийлөн захирагч дунджаар 108 орчим харьяа байгууллагатай ба 2021 онд нэг байгууллага дунджаар 152 удаа мэдээлэл байршуулахаас 146 орчим удаа мэдээлэл байршуулж, ТЕЗ нарын шилэн дансны хөтлөлт дунджаар **96.2%**-ийн биелэлттэй буюу шилэн дансны хуулийг ТЕЗ нар "хангалттай сайн" хэрэгжүүлж ажилласан байна. Доорх хүснэгтээс ТЕЗ тус бүрээр 2021 онд шилэн дансны цахим нэгдсэн системд байршуулсан мэдээллийн үнэлгээг үзнэ үү.

№	ТЕЗ нарын нэрс	Харьяа байгууллагын тоо	Мэдээлэл оруулах давтамжийн тоо /1 байгууллагад дунджаар/	Мэдээлэл оруулсан давтамжийн тоо /1 байгууллагад дунджаар/	Үнд:		Хэрэгжилтийн хувь
					Хугацаандаа	Хугацаа хоцроосон	
1	Архангай аймаг	175	151	142	127	15	94.9%
2	Баян-Өлгий аймаг	173	150	148	131	17	98.4%
3	Баянхонгор аймаг	188	146	142	128	14	97.6%

№	ТЭЗ нэрийн нэр	Харьяа байгууллагын тоо	Мэдээлэл оруулах давтамжийн тоо /1 байгууллагад дунджаар/	Мэдээлэл оруулсан давтамжийн тоо /1 байгууллагад дунджаар/	Үүнд:		Хэрэгжилтийн хувь
					Хугацаандаа	Хугацаа хоцровсон	
4	Булган аймаг	153	149	148	141	7	98.9%
5	Дархан-Уул аймаг	94	149	148	141	7	98.9%
6	Дорнод аймаг	164	149	146	140	6	97.7%
7	Дорноговь аймаг	148	148	147	144	3	99.3%
8	Дундговь аймаг	144	151	145	133	13	96.4%
9	Говь-Алтай аймаг	178	150	147	139	8	97.7%
10	Говьсүмбэр аймаг	48	153	143	135	8	94.3%
11	Завхан аймаг	201	150	147	134	13	97.8%
12	Орхон аймаг	87	148	143	136	7	96.2%
13	Өвөрхангай аймаг	199	150	148	135	13	98.7%
14	Өмнөговь аймаг	180	149	145	134	11	97.4%
15	Сүхбаатар аймаг	140	151	142	125	16	94.5%
16	Сэлэнгэ аймаг	206	149	142	124	18	95.2%
17	Төв аймаг	246	151	143	129	14	95.5%
18	Увс аймаг	173	151	150	141	9	99.4%
19	Ховд аймаг	168	151	148	133	15	98.2%
20	Хөвсгөл аймаг	232	147	142	133	9	96.6%
21	Хэнтий аймаг	194	146	141	135	6	96.6%
22	Нийслэл	660	148	140	129	12	94.1%
<b>ДУНДАЖ ДҮН</b>			<b>152</b>	<b>146</b>	<b>134</b>	<b>12</b>	<b>96.2%</b>

Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд бүртгэлтэй 7445 байгууллага, хуулийн этгээд буюу 4656 төсвийн байгууллага, 582 төрийн болон орон нутгийн өмчит компани, 122 төсөл, хөтөлбөр, 72 засгийн газрын тусай сан, 2013 ТББ, нөхөрлөл хоршоо, аж ахуйн нэгж, иргэн хагас, бүтэн жил, улирал, сар, тухай бүр мэдээлэл байршуулсныг төсвийн ерөнхийлөн захирагчаар ангилан авч үзэхэд хуулийн хэрэгжилт 96.2 хувьтай байна.

### Зөвлөмж

- Төсвийн ерөнхийлөн захирагч бүр Шилэн дансны тухай хуулийг чанд мөрдөж, тогтоосон хугацаанд нь холбогдох мэдээллийг цахим хуудсанд иж бүрэн, үнэн зөв мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг байнга хангаж ажиллах;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоллоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 8.5-д заасны дагуу ТЭЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын нэгж Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийг сайжруулах.

### 5.3. Шударга байдлын үнэлгээ

Шударга байдлын үнэлгээний судалгааны асуулга, зааврын дагуу мэдээллийг цуглуулах, цуглуулсан мэдээлэлд үндэслэн тооцооллыг хийж, тайланг боловсруулан үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг гүйцэтгэх үндсэн зорилгын хүрээнд судалгаа, зөвлөх үйлчилгээний "Эс Ай Си Эй" ХХК нь энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгаанд 14 яам, 32 агентлаг, 21 аймаг болон нийслэлийн ЗДТГ хамрагдсан. Үүнийг нэгжийн хувьд авч үзвэл ГШБҮ-д нийт 7,440 иргэн, ДШБҮ-д 1,550 төрийн албан хаагч, БОҮ-д 860 шинжээч буюу нийт 9,850 оролцогчийг хамруулсан.

### **Ерөнхий мэдээлэл**

ГШБҮ-д хамрагдсан 10 оролцогч тутмын 8 нь хувь хүний хувьд төрийн байгууллагаас үйлчилгээ авсан бол 2 нь ААНБ-ыг төлөөлж үйлчилгээ авсан байлаа. Оролцогчдыг насны хувьд ангилан авч үзвэл дийлэнх нь буюу 10 оролцогч тутмын 5 нь 20-39 насныхан байв. Өөрөөр хэлбэл энэхүү судалгаанд залуу, идэр насныхан түлхүү хамрагдсан байна. Харин хүйсийн хувьд 48.2 хувь нь эрэгтэйчүүд, 51.8 хувь нь эмэгтэйчүүд байсан нь Монгол Улсын нийт хүн амын хүйсийн харьцаатай ойролцоо байв.

ДШБҮ-д хамрагдсан албан хаагчдын 23.9 хувь нь төрийн захиргааны төв байгууллага буюу яам, 49.0 хувь нь төрийн захиргааны байгууллага буюу агентлаг, 27.1 хувь нь аймаг, нийслэлийн ЗДТГ-ын төлөөлөл байсан. Албан хаагчдын ажилласан жилийн ангиллын хамгийн их хувийг буюу 44.5 хувийг 5 хүртэл жил ажилласан албан хаагч эзэлж байв.

БОҮ-д нийт 860 оролцогч хамрагдсанаас 52.4 хувийг төрийн албан хаагч, 12.8 хувийг төрийн бус байгууллагын төлөөлөл, 11.0 хувийг хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, 8.3 хувийг аудитор, хяналтын ажилтан, 6.9 хувийг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, 4.7 хувийг эрдэмтэн судлаач, 3.8 хувийг бодлого боловсруулагч, 0.1 хувийг олон улсын байгууллагын төлөөлөл тус тус эзэлж байв.

### **Шударга байдлын үнэлгээ**

Төрийн байгууллагуудын ШБҮ 2021 онд 72.9 болж өмнөх үнэлгээний дүнгээс 1.2 пунктээр буурсан байна. Ийнхүү буурсан үр дүнд ГШБҮ 4.7 пунктээр буурсан нь нөлөөлсөн байв.

Энэ удаагийн ШБҮ-ний судалгаагаар ДШБҮ өмнөх үнэлгээний дүнгээс 0.4 пунктээр, БОҮ 0.6 пунктээр тус тус өсжээ. ДШБҮ 2018 оноос хойш тогтвортой өсөлттэй байна. БОҮ-ний хувьд энэ удаагийн үр дүн нь ШБҮ-ний судалгаа хийгдэж эхэлснээс хойших хамгийн өндөр үнэлгээ байв. Харин ГШБҮ өмнөх үнэлгээний дүнгээс 4.7 пунктээр буурсан нь төрийн байгууллагуудын ил тод, хариуцлагатай байдлын индекс, авлигын индекс буурснаас хамаарсан байв. Өөрөөр хэлбэл төрийн үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчид ил тод, хариуцлагатай байдал буурсан, авлигын шууд болон шууд бус тохиолдол нэмэгдсэн, албан хаагчид төрийн үйлчилгээг хүргэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлдэг, ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг, бусдад хууль бусаар давуу байдал олгодог явдал ихэссэн гэж үзсэн байна.

### **Гадаад шударга байдлын үнэлгээ**

ГШБҮ 67.0 болж 2019 онтой харьцуулахад 4.7 пунктээр, 2015 онтой харьцуулахад 2.8 пунктээр буурсан байна. ГШБҮ-ний дундаж үнэлгээ ШБҮ-ний дунджаас 5.9 пунктээр бага байгаа нь үйлчлүүлэгчдийн хувьд төрийн байгууллагуудын шударга байдалд тааруу үнэлгээ өгч байгааг илтгэж байна.

### **Дотоод шударга байдлын үнэлгээ**

ДШБҮ 81.2 болж 2019 онтой харьцуулахад 0.4 пунктээр нэмэгджээ. ДШБҮ-ний дундаж үнэлгээ ШБҮ-ний дунджаас 8.3 пунктээр илүү байгаа нь албан хаагчид байгууллагынхаа шударга байдлыг сайнаар үнэлж байгааг илэрхийлж байна.

### **Бодлогод оролцогчдын үнэлгээ**

БОҮ 70.4 болж 2019 онтой харьцуулахад 0.6 пунктээр, өсжээ. БОҮ-ний дундаж үнэлгээ ШБҮ-ний дунджаас 2.5 пунктээр бага байгаа боловч 2015 оноос хойших хамгийн өндөр үнэлгээ юм. Ийнхүү өсөхөд БОҮ-д оролцогчдын авлигын талаарх төсөөлөл, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл зэрэг үзүүлэлтүүдийг сайнаар үнэлсэн нь голлон



нөлөөлжээ.

### **Монгол Улсын авлигын нөхцөл байдал, АТГ-ын үйл ажиллагааны үнэлгээ**

Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь буюу 45.1 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл байдаг хэмээн хариулжээ. Энэхүү үр дүнг 2016 онтой харьцуулахад 6.1 пунктээр, 2019 онтой харьцуулахад 3.3 пунктээр тус тус буурчээ. Харин ихээхэн түгээмэл байдаг хэмээн хариулсан хариултын хувь 2021 онд 20.9, 2019 онд 23.0 хувийг эзэлж байв. Ийнхүү буурсан нь авлигын өнөөгийн нөхцөл байдлын талаар хэлж мэдэхгүй байна гэж үзэх иргэдийн хувь нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Ерөнхийдөө судалгаанд хамрагдсан 10 оролцогч тутмын 7 нь Монгол Улсад авлига түгээмэл байдаг гэдэгтэй санал нэгдэж байсан. Энэхүү үр дүн 2016 оноос хойш төдийлөн өөрчлөгдөөгүй байлаа.

Судалгаанд оролцсон 10 хүн тутмын 3 нь ирэх 2 жилийн хугацаанд Монгол Улсад авлигын нөхцөл байдал өөрчлөгдөхгүй гэж хариулсан бол, 2 нь буурна, 2 нь өснө гэж үзсэн байна.

Иргэд, ААНБ-ын төлөөллийн 19.8 хувь нь ирэх 2 жил авлигын нөхцөл байдал өснө гэсэн байгаа нь албан хаагчид болон бодлогод оролцогчдын төлөөллөөс харьцангуй их байна. Үр дүнгээс дүгнэхэд ирэх жилүүдэд Монгол Улс дахь авлигын түвшин буурна гэдэгт иргэд, ААНБ-ын төлөөллүүд итгэлгүй байна.

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институц аль нь болохыг тодруулахад “Эрүүл мэндийн байгууллага” гэж хариулсан бөгөөд өмнөх үнэлгээтэй харьцуулахад 5.7 пунктээр нэмэгдэж нэгт эрэмбэлэгджээ. “Шүүхийн байгууллага” өмнөх үнэлгээтэй харьцуулахад 5.3 пунктээр буурсан хэдий ч хоёрдугаарт эрэмбэлэгдсэн байна. ШБҮ-ний 2016 оноос хойших судалгаануудын үр дүнг харьцуулахад Шүүх, Газрын алба, Эрүүл мэндийн байгууллага нь авлига хамгийн их тархсан институцын эрэмбээр эхний 3 байрт эрэмбэлэгдэж байгаагаас үзэхэд эдгээр байгууллагуудад тархсан авлигыг бууруулах, таслан зогсоох тал дээр нэн тэргүүнд анхаарал хандуулж ажиллах хэрэгцээ, шаардлага байна.

Судалгаанд оролцогчдоос Монгол Улсын авлигын шалтгааныг тодруулахад цалин орлого бага, хувь хүний ёс зүйгүй, хэм, хэмжээгүй байдал, ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, хүнд суртал, албан тушаал эрх мэдлээ урвуулан ашигладаг байдал зэрэг хариултууд өндөр хувийг эзэлж байна. Харин 10 оролцогч тутмын 2 нь энэ талаар хэлж мэдэхүй байна гэж хариулсан байв.

Судалгаанд оролцогчдоор АТГ-ын үйл ажиллагааг үнэлүүлж үр дүнг 2019 онтой харьцуулахад үйл ажиллагаа нь үр ашигтай хэмээн үзсэн оролцогчдын үнэлгээ 28.6 пунктээр буурсан байна.

**График 6. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ШБҮ, 2021 он, оноогоор**

Хэнтий аймгийн ЗДТГ	81.1
Өвөрхангай аймгийн ЗДТГ	78.4
Увс аймгийн ЗДТГ	77.8
Орхон аймгийн ЗДТГ	76.5
Сэлэнгэ аймгийн ЗДТГ	76.3
Дархан-Уул аймгийн ЗДТГ	74.6
Төв аймгийн ЗДТГ	74.5
Сүхбаатар аймгийн ЗДТГ	72.9
Улсын дундаж	72.9
Дундговь аймгийн ЗДТГ	72.8
Говь-Алтай аймгийн ЗДТГ	72.4
Нийслэлийн ЗДТГ	72.0
Булган аймгийн ЗДТГ	71.5
Дорнод аймгийн ЗДТГ	71.4
Говьсүмбэр аймгийн ЗДТГ	68.8
Баянхонгор аймгийн ЗДТГ	68.8
Өмнөговь аймгийн ЗДТГ	68.4
Завхан аймгийн ЗДТГ	68.2
Дорноговь аймгийн ЗДТГ	68.0
Архангай аймгийн ЗДТГ	68.0
Ховд аймгийн ЗДТГ	67.3
Баян-Өлгий аймгийн ЗДТГ	61.8
Хөвсгөл аймгийн ЗДТГ	59.0

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Төрийн байгууллагыг авлигаас ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг хэлбэр нь ШБҮ-ний судалгаа юм. Судалгааны үр дүнд үндэслэн авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тэдгээрийг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд дараах дүгнэлтэд хүрч байна.

- 2021 оны ШБҮ-ээр 100 онооноос дунджаар 72.9 оноо авсан нь өмнөх оноос 1.2 пунктээр буурсан байна. ШБҮ ийнхүү буурахад төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өгсөн үнэлгээ 4.7 пунктээр буурсан нь ихээхэн нөлөөлсөн байна.
- Үйлчлүүлэгч иргэд ААНБ-ын төлөөлөл яамдыг, албан хаагчид болон бодлогод оролцогчид агентлагуудыг хамгийн өндөр үнэлгээгээр үнэлсэн байна.
- ГШБҮ буюу төрийн байгууллагаар үйлчлүүлэгч, иргэдийн үнэлгээнээс харахад байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагатай байдалд анхаарч ажиллах шаардлагатай байна.
- Түүнчлэн ГШБҮ-г буурахад нөлөөлсөн өөр нэгэн үзүүлэлт болох авлигын индексийн дэд үзүүлэлтүүд болох авлигын шууд болон шууд бус тохиолдол нэмэгдсэн байгаа нь цаашид төрийн үйлчилгээг хүргэхдээ үйлчлүүлэгчдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах зэрэг үйлдлийг таслан зогсоох шаардлагатай байна. ДШБҮ өмнөх онтой харьцуулахад 0.4 пунктээр, ШБҮ-ний дундажтай харьцуулахад 8.3 пунктээр өссөн байгаагаас харахад албан хаагчид байгууллагынхаа шударга байдлыг хамгийн өндрөөр үнэлдэг хандлага хадгалагдаж ирсэн байлаа.
- ДШБҮ-г тооцоход ашигласан үзүүлэлт болох Соёлын индекс 73.3 гарсан нь 2019 онтой харьцуулахад 0.8 пунктээр өссөн байв. Энэхүү үр дүн нь ДШБҮ-ийн дундаж

- үнэлгээнээс 8.8 пунктээр бага байгаа нь албан хаагчдын хэм хэмжээг хэтрүүлэн ашиглах тохиолдол нэлээдгүй байдаг болон тухайн байгууллагад авлигын эсрэг тогтолцоо хангалттай бүрдээгүй зэргээс шалтгаалж байсан тул цаашид төрийн байгууллагууд энэ чиглэлд дотоод үйл ажиллагаагаа сайжруулах шаардлагатай.
- ДШБҮ-г тооцоход ашигласан үзүүлэлт болох төсвийн зарцуулалтыг зарим тохиолдолд яагаад зориулалтын бусаар ашигладаг болохыг тодруулахад удирдлагын шийдвэрээр гэж хариулсан албан хаагчдын хувь 2019 онтой харьцуулахад 5.8 пунктээр буурсан боловч төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал нь удирдлагын шийдвэртэй шууд хамааралтай байдаг нь хэвээр хадгалагдсаар байгаа нь бодлого боловсруулагчдын хувьд анхаарал хандуулж хяналтын механизмыг сайтар ажиллуулах хэрэгцээ байна. БОҮ-ний судалгаанд оролцогчид төрийн байгууллагуудын авлигыг хянах механизм тааруу байна хэмээн үнэлсэн байгаагаас үзэхэд цаашид дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлэх, хариуцлага тооцох, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалах, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх зэрэг чиглэлд ажиллах шаардлагатай гэж үзэж байна.
  - Судалгаанд хамрагдсан 10 оролцогч тутмын 7 нь Монгол Улсад авлига түгээмэл байдаг гэдэгтэй санал нэгдэж байсан ба ирэх жилүүдэд Монгол Улс дахь авлигын түвшин буурна гэдэгт иргэд, ААНБ-ын төлөөллүүд итгэлгүй байна.
  - Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институц аль нь болохыг тодруулахад “Эрүүл мэндийн байгууллага” өмнөх үнэлгээтэй харьцуулахад 5.7 пунктээр нэмэгдэж нэгт эрэмбэлэгджээ. “Шүүхийн байгууллага” өмнөх үнэлгээтэй харьцуулахад 5.3 пунктээр буурсан хэдий ч хоёрдугаарт эрэмбэлэгдсэн байна. Үүний дараа “Газрын алба”, “Гаалийн байгууллага”, “Цагдаагийн байгууллага” эрэмбэлэгдсэн байв. Энэхүү үр дүнг 2018 онтой мөн харьцуулахад Шүүх, Газрын алба, Эрүүл мэндийн байгууллага 3 онд дараалан эхний 5-д эрэмбэлэгдсэн тул эдгээр байгууллагуудад тархсан авлигыг бууруулах, таслан зогсоох тал дээр нэн тэргүүнд анхаарал хандуулж ажиллах хэрэгцээ, шаардлага байна.
  - Албан хаагчдын 13.0 хувь нь Монгол Улсын авлигын шалтгаан, нөхцөлийг цалин, орлого бага байгаагаас хамаарч байна хэмээн үзэж байна. Иргэд, ААНБ-ын төлөөллийн хувьд албан хаагчдын ёс зүйгүй байдал, хүнд суртал, үйлчлүүлэгчдийн ажлаа хурдан шуурхай, амжилттай бүтээх хүсэл, авлига авсан болон өгсөн хүнд хариуцлага тооцдоггүй тогтолцоо зэрэг нь Монгол Улсын авлигын шалтгаан, нөхцөл болж байна хэмээн үзэж буй нь түлхүү ажиглагдаж байв. Харин бодлогод оролцогчдын хувь ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашигладаг байдал, хуулийн хэрэгжилт, зохицуулалт сул, улс төр, намын нөлөө их, иргэдийн авлигын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг, ил тод бус байдал, ажилгүйдэл болон ажлын байрны хомсдол зэрэг нь Монгол Улсын авлигын шалтгаан, нөхцөл хэмээн үзсэн байна.
  - АТГ-ын үйл ажиллагааг ихээхэн үр ашигтай гэж хариулсан хариултын хувь өмнөх оноос 1.9 пунктээр, үр ашигтай гэсэн нь 21.8 пунктээр, дунд зэрэг гэсэн нь 4.9 пунктээр тус тус буурчээ. Энэ нь АТГ-ын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар болон авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гэмт хэргийн бүртгэл, шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл олон нийтэд төдийлөн нээлттэй биш байгааг илэрхийлж байна. Иймд цаашид үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээ, мэдээлэл тогтмол хүргэж байх нь чухал юм.